



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.02.25 № 1/02 ЧАГ-САГ/2014/22/СТА-ТЦЗ

Зөрчлийг арилгах тухай

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Орон сууцны хороолол, дэд бүтэц төслийн 2013 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Тус төслийн 2013 оны санхүүгийн тайланд 118.3 сая төгрөгийн авлагыг бүртгэж, Барилгын хөгжлийн төвтэй тооцоо нийлээгүй зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

1. БХБЯ-ны харъяа Барилгын хөгжлийн төвтэй 118.3 сая төгрөгийн тооцоог хийх.
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Орон сууцны хороолол, дэд бүтэц төслийн зохицуулагч Ч.Доржготов, төслийн нягтлан бодогч Т.Золзаяа нарт хариуцуулав.

АУДИТОР



Р.ЦОЛМОН